



247

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/97

Мандалговь

Шалгуур үзүүлэлт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Журам батлах тухай” 5 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн “Шагналын журам батлах тухай” А/88 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шилдэг төрийн албан хаагч” шалгаруулах шалгуур үзүүлэлтийг нэгдүгээр, “Эрүүл мэндийн салбарын оны шилдэг эмч” шалгаруулах шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар, “Оны шилдэг сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн” шалгаруулах шалгуур үзүүлэлтийг гуравдугаар, “Оны шилдэг ажилтан” шалгаруулах шалгуур үзүүлэлтийг дөрөвдүгээр, “Оны шилдэг мэргэжилтэн” шалгаруулах шалгуур үзүүлэлтийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шилдэгүүдийг шалгуур үзүүлэлтийн дагуу жил бүр шалгаруулж Удирдлагын багт танилцуулахыг Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Ц.Энхсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.АЛТАНТӨГС



Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
А/97 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ШИЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ
ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	Авах оноо	Авбал зохих оноо	Тайлбар
1	Үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ сүүлийн 5 жилд 90-ээс дээш хувиар биелүүлсэн байх (үр дүнгийн гэрээний хэрэгжилт хавсралтаар)	5 оноо		
2	Тухайн онд ажлын арга барил, санаачилж хийсэн бүтээлч ажил нь эрүүл мэндийн салбарт бодитой үр дүн өгч, ажлын арга барил, туршлага нь нийтэд дэлгэрүүлсэн байх	10 оноо		
3	Төрийн албаны болон эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллаж, эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний талаар үйлчлүүлэгчдээс санал, гомдол ирээгүй байх	5 оноо		
4	Хариуцсан ажлын хүрээнд үйлчлүүлэгчдэдээ хүрч үйлчилсэн нь үр дүнгээ өгсөн, иргэд үйлчлүүлэгчдэд сэтгэл ханамжтай чанартай ажил үйлчилгээ хүргэсэн байх, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 90-ээс доошгүй байх,	10 оноо		
5	Эмчилгээ үйлчилгээнд оношилгооны шинэ арга, технологи нэвтрүүлсэн байх (Төрийн захиргааны албан хаагчид хамааралгүй)	10 оноо		
6	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажилд орон нутагтаа санаачлагатай ажилласан байх.	10 оноо		
7	Анагаах ухааны чиглэлээр ном товхимол, эрдэм шинжилгээний өгүүлэл, санамж зөвлөмж бичиж, онол практикийн хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэн байх.	10 оноо		
8	Яаралтай тусламж, амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй газар дээр нь мэргэжлийн ур чадвар гарган ажиллаж, хүний амь насыг аварсан байх (Төрийн захиргааны албан хаагчид хамааралгүй)	10 оноо		
9	Төрийн болон иргэний нийгэм, олон улсын байгууллага, иргэд олон нийттэй хамтран ажиллаж үр дүнд хүрсэн байх	10 оноо		
10	Мэргэшил ур чадвараа дээшлүүлж, мэргэжлийн сургалтад хамрагдсан байх, мэргэжлийн зэрэг хамгаалсан болон ахиулсан байх	10 оноо		
11	Хамтран ажиллах арга туршлагыг хуримтлуулж, бусад төрийн албан хаагчдын хөгжилд хувь нэмэр оруулахад дэмжин тусалсан, бүтээлч ажлуудыг санаачлан хийсэн байх	5 оноо		
12	Байгууллага хамт олны хурлын тэмдэглэл, бүтээлч ажлын зураг, сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээ (хавсралтаар)	5 оноо		

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
А/97 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН “ШИЛДЭГ ЭМЧ”
ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	Оноо	Авбал зохих оноо	Тайлбар
1	Үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ сүүлийн 3 жилд 90% түүнээс дээш хувиар биелүүлсэн байх (үр дүнгийн гэрээний хэрэгжилт хавсралтаар)	10 оноо		
2	Үндэсний хэмжээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, зорилго зорилтуудыг хэрэгжүүлж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажилд орон нутагтаа санаачлага гаргаж, шинээр ажил үйлчилгээ нэвтрүүлсэн эсэх	10 оноо		
3	Эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд илтгэл, өгүүлэл хэлэлцүүлсэн байх	10 оноо		
4	Хариуцсан ажлын хүрээнд үйлчлүүлэгчдэдээ хүрч үйлчилсэн нь үр дүнгээ өгсөн, иргэд үйлчлүүлэгчдэд сэтгэл ханамжтай чанартай ажил үйлчилгээ хүргэсэн байх, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 90% доошгүй байх,	10 оноо		
5	Төрийн албаны болон эмчийн ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллаж, эмчийн ёс зүйн хэм хэмжээний талаар үйлчлүүлэгчдээс санал, гомдол ирээгүй байх	10 оноо		
6	Хүн амын 90 хувийг дархлаажуулалт вакцинд төлөвлөгөөний дагуу бүрэн хамруулсан байх. Уламжлалт анагаах ухааныг европ анагаах ухаантай хослуулж, хүн амын эрүүл мэнд сайжирч, үр дүнтэй үзүүлэлтүүд давтамжтай гарсан байх (биелэлт 90%)	10 оноо		
7	Ажлын үзүүлэлтүүдэд чанарын ахиц дэвшил гарч, Жирэмсний хяналт, нярайн эргэлтийг сарчилсан байдлаар төлөвлөгөөнд тусгаж, эх хүүхдийн эндэгдэлгүй байх тал дээр бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх (биелэлт 100%)	10 оноо		
8	Жирэмсэн эх, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настанд үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарт үнэлэлт дүгнэлт өгч тодорхой асуудал дэвшүүлэн шийдвэрлэсэн эсэх	10 оноо		
9	Эмчилгээ үйлчилгээнд шинэ арга нэвтрүүлж, үр дүнг нь тооцож “сайн” үйл ажиллагаандаа хэрэглэж, илүү хөгжүүлж, чадавхжуулж, бусад мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулсан байх	10 оноо		
10	Байгууллага хамт олны хурлын тэмдэглэл, бүтээлч ажлын зураг, сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээ (хавсралтаар)	10 оноо		

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
А/97 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН “ШИЛДЭГ СУВИЛАГЧ, ЭМНЭЛГИЙН
МЭРГЭЖИЛТЭН” ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	Оноо	Авбал зохих оноо	Тайлбар
1	Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ сүүлийн 3 жилд 85-90% түүнээс дээш хувиар биелүүлсэн байх (төлөвлөгөөний хэрэгжилт хавсралтаар)	10 оноо		
2	Олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцсон санаачлан зохион байгуулсан арга хэмжээ	10 оноо		
3	Үндэсний төсөл хөтөлбөр, зорилго, зорилтыг хэрэгжүүлж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажилд орон нутагтаа хэрэгжүүлсэн байх.	10 оноо		
4	Эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд илтгэл, өгүүлэл хэлэлцүүлсэн байх	10 оноо		
5	Мэдлэг мэргэжил болон багаар ажиллах чадвараа дээшлүүлж байгууллагын соёлд хувь нэмрээ оруулж хэрэгжүүлсэн арга хэмжээ 2-с доошгүй хийсэн байх	10 оноо		
6	Хариуцсан ажлын хүрээнд үйлчлүүлэгчдэдээ хүрч үйлчилсэн нь үр дүнгээ өгсөн, иргэд үйлчлүүлэгчдэд сэтгэл ханамжтай чанартай ажил үйлчилгээ хүргэсэн байх, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 90% доошгүй байх,	10 оноо		
7	Төрийн албаны болон эмчийн ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллаж, эмчийн ёс зүйн хэм хэмжээний талаар үйлчлүүлэгчдээс санал, гомдол ирээгүй байх	10 оноо		
8	Жирэмсэн эх, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настанд үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарт үнэлэлт дүгнэлт өгч тодорхой асуудал дэвшүүлэн ажилласан байх	10 оноо		
9	Шинэ санал санаачлага гаргаж, эмчилгээ үйлчилгээнд нэвтрүүлж, үр дүнг нь тооцож хэрэгжүүлсэн байх	10 оноо		
10	Байгууллага хамт олны хурлын тэмдэглэл, бүтээлч ажлын зураг, сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээ (хавсралтаар)	10 оноо		

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
А/97 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН “ШИЛДЭГ АЖИЛТАН”
ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	Оноо	Авбал зохих оноо	Тайлбар
1	Ажилдаа бүтээлч шинэлэг, санал санаачлагыг хэрэгжүүлж үр дүнг тооцсон байх	10 оноо		
2	Ажил үйлчилгээг хэрэгжүүлэхдээ төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн байх	10 оноо		
3	Сайн туршлага нэвтрүүлэх, бусдад ажлаа танилцуулах чиглэлээр санаачлагатай ажилласан байх	10 оноо		
4	Цэвэрлэгээ, үйлчилгээ зэрэг ажлын үзүүлэлтүүдэд чанарын ахиц дэвшил гарсан байх	10 оноо		
5	Эд хөрөнгийн хариуцлагын гэрээг дагаж мөрдөж ажиллаж, техник хэрэгслийг хэрэглээний сэв, доголдолгүй бүрэн бүтэн эдэлж хэрэглэсэн байх	10 оноо		
6	Байгууллагын соёлыг төлөвшүүлэхийн тулд хувцаслалт, цаг ашиглалтад ажил үүргийн хуваарьт онцгой анхаарч, түүнд сэтгэл гаргаж үнэнчээр ажилласан байх	10 оноо		
7	Мэдлэг, мэдээлэл авч өөрийгөө хөгжүүлэх, компьютерийн наад захын хэрэглээний программ дээр ажиллаж сурсан байх	10 оноо		
8	3 сардаа нэг шинэ санал санаачлага дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлсэн байх	10 оноо		
9	Жилд 2-3 удаа байгууллагаас өөрийгөө хөгжүүлэх тал дээр анхаарч сургалт авсан байх	10 оноо		
10	Байгууллага хамт олны хурлын тэмдэглэл, бүтээлч ажлын зураг, сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээ (хавсралтаар)	10 оноо		

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
А/97 дугаар тушаалын 5 дугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН “ШИЛДЭГ МЭРГЭЖИЛТЭН”
ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	Оноо	Авбал зохих оноо	Тайлбар
1	Шинээр сургалтын хөтөлбөр боловсруулж, цогцоор нь нэвтрүүлсэн байдал (хөтөлбөр боловсруулж, тохирох хэрэглэгдэхүүнийг бэлтгэн, мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавьж түүнийг олон нийт болон алба хаагчдын дунд түгээн дэлгэрүүлсэн байдал)	10 оноо		
2	Ажилдаа гаргасан онцгой амжилт буюу шинэ санаачилга гаргаж, бүтээлч ажил болгосон, шинэ арга барил нэвтрүүлсэн, түгээсэн байдал	10 оноо		
3	Мэргэжлийн чиглэлээр гадаад, дотоодын байгууллагатай хамтын ажиллагаа амжилттай хэрэгжүүлсэн байх.	10 оноо		
4	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь (90 хувиас доошгүй)	10 оноо		
5	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажилд орон нутагтаа хэрэгжүүлсэн эсэх	10 оноо		
6	Хамтран ажиллах арга туршлагыг хуримтлуулж, бусад төрийн албан хаагчдын хөгжилд хувь нэмэр оруулахад дэмжин тусалсан, бүтээлч ажлуудыг санаачлан хийсэн байх	10 оноо		
7	Төрийн болон иргэний нийгэм, олон улсын байгууллага, иргэд олон нийттэй хамтран ажиллаж, дэмжин туслах үйл ажиллагаа нь иргэд, олон нийтийн дунд дэлгэрч, бодитой үр дүнд хүрсэн байх	10 оноо		
8	Тухайн хүний харилцааны соёл, ёс зүй, хамт олонч байдлын талаарх хамт олны сэтгэл ханамжийн судалгааны дүн 98-100%	10 оноо 10 оноо		
9	Мэргэжил арга зүйн чиглэлээр ном товхимол, санамж зөвлөмж бичиж, онол практикийн хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэн байх	10 оноо		
10	Байгууллага хамт олны хурлын тэмдэглэл, бүтээлч ажлын зураг, сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээ (хавсралтаар)	10 оноо		